

Э-Сонин

30 дахь дугаар



Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

3 ДАХЬ ЭЭЛЖИЙН 100.0 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ
ЦААСЫГ НЭМЖ БҮРТГЭГДЛЭЭ



ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕРИЙН ТАЙЛАН

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИДЭВХ НЭМЭГДЭЖ БАЙНА

ЗГҮЦ-НЫ НИЙТ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ 7.5
ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙНА



МХБ-ИЙН 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Т.ЖАМБААЖАМЦ: ЗАХ ЗЭЭЛИЙГ
УРВУУЛАН АШИГЛАХ
ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ БАЙСАН



ТӨГСӨЛТИЙН БАЯР

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН
МЭДЛЭГ ОЛГОХ
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 4 дүгээр сарын арилжааны мэдээлэл.
- 3 дахь 100 тэрбум төгрөгийн засгийн газрын үнэт цаас нэмж бүртгэгдлээ.
- МХБ-ээс Итгэмжлэгдсэн дилерүүдийн үйл ажиллагааны биелэлтийг дүгнэсэн тайлан гаргалаа.
- Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэлгэрэнгүй мэдээллийг гаргав.
- Өмнөх 2015 оны эхний улирлыг 2014 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө оруулагчдын идэвх эрс нэмэгдсэн байна.
- ЗГҮЦ-ны өгөөжийн хэмжээ нь 7.5 тэрбум төгрөг байна.
- МХБ 1-р улирлын шилэн дансны мэдээллээ гаргав.
- Т.Жамбаажав: Зах зээлийг урвуулан ашиглах зөрчил өмнө нийтлэг байсан.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 4-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт-ыг 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.


Дэлгэрэнгүй мэдээллийг 11323715 -116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Лхагва гарагаас дараа долоо хоногийн Мягмар гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Дөрөвдүгээр сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж нийт 55.1 тэрбум төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Өдөр	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2015.04.07	ЗГЭБ-Б-52-297	12	337,511	15.185%	32,611,325,353.00
2015.04.14	ЗГЭБ-Б-12-298	28	2,652	15.80%	244,458,708.00
2015.04.14	ЗГЭБ-Б-12-299	156	29	16.875%	2,900,000.00
2015.04.21	ЗГЭБ-Б-12-300	12	209,049	14.988%	20,207,930,634.00
2015.04.28	ЗГЭБ-Б-52-302	52	20,891	16.0%	2,089,100,000.00
2015.04.28	ЗГЭБ-Б-28-303	360	20	16.75%	2,000,000.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ			570,152		55,157,714,695.00





3 ДАХЬ ЭЭЛЖИЙН 100.0 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС НЭМЖ БҮРТГЭГДЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10-р сарын 21-ний 389 тоот тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсан билээ.

Өнгөрсөн хугацаанд урт болон богино хугацаат ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг 26 удаа зохион байгуулж, нийт 183.4 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжсан байна. Сангийн яамны үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийн дагуу 3 дахь ээлжийн 100 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэн авлаа.

ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕРИЙН ТАЙЛАН

Монголын хөрөнгийн биржээс олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц болох “Market makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байгаа билээ.

Үүнтэй холбоотойгоор Итгэмжлэгдсэн дилерүүдийн үйл ажиллагааны биелэлтийг дүгнэж, хагас сар тутам мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэхээр боллоо.

“Итгэмжлэгдсэн дилер” үнэт цаасны компаниуд арилжааны өдөр бүр ЗГҮЦ худалдах, худалдан авах үнийн саналыг давхар гаргах бөгөөд 4-р сарын 1-15-ны хооронд нийт 362 захиалга байршуулахаас, биелэлтийн хувиар авч үзэхэд “Бидисек ҮЦК”-н хувьд 29%, “Стандарт инвестмент ҮЦК”-н хувьд 51.9%, “Тэнгэр капитал ҮЦК”-н хувьд 23.8% тус тус байна.

4-р сарын 15-ны байдлаар

№	ҮЦК-ийн нэр	Байршуулбал зохиx захиалгын тоо	Бүртгэгдсэн захиалгын тоо	Захиалга байршуулсан биелэлтийн хувь /%/
1	Бидисек	362	105	29.0
2	Стандарт инвестмент	362	188	51.9
3	Тэнгэр капитал	362	86	23.8
4	Монсек *	362	-	-

*Монсек ҮЦК нь 2015оны 3-р сарын 24-ний өдөр нэмэгдсэн тул Итгэмжлэгдсэн дилерийн тайланд 5-р сараас эхлүүлэн тооцно.


ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Үнэт цаасны код	ЗГҮЦ-ны нэр	Хугацаа /Пхоног/	Хүүгийн хэмжээ	Нэрлэсэн үнэ	Хямдруулсан үнэ	Үнийн дүн	Хүү төлөгдөх хэлбэр	Дуусах хугацаа
1	1096	ЗГЭБ-Б-12-274	12	15.795	100,000	96,493	4,344,114,860	хямдруулсан	2015.01.27
2	1097	ЗГЭБ-Б-52-275	52	16.25	100,000	-	230,400,000	Сар бүр	2015.11.10
3	1098	ЗГЭБ-Б-12-276	12	15.99	100,000	96,451	5,337,308,987	хямдруулсан	2015.02.10
4	1099	ЗГЭБ-Б-28-277	28	16.3	100,000	91,952	2,295,213,872	хямдруулсан	2015.06.09
5	1100	ЗГЭБ-Б-12-278	12	15.96	100,000	96,457	2,586,590,912	хямдруулсан	2015.02.24
6	1101	ЗГЭБ-Б-52-279	52	16.625	100,000	-	205,700,000	Сар бүр	2015.12.08
7	1102	ЗГЭБ-Б-12-280	12	15.731	100,000	96,506	14,763,294,868	хямдруулсан	2015.03.10
8	1103	ЗГЭБ-Б-28-281	28	16.436	100,000	91,890	449,158,320	хямдруулсан	2015.07.07
9	1104	ЗГЭБ-Б-12-282	12	15.653	100,000	96,523	5,905,084,094	хямдруулсан	2015.03.24
10	1106	ЗГЭБ-Б-12-284	12	14.690	100,000	96,730	12,582,348,210	хямдруулсан	2015.04.07
11	1107	ЗГЭБ-Б-28-285	28	15.292	100,000	92,411	304,309,423	хямдруулсан	2015.08.04
12	1108	ЗГЭБ-Б-12-286	12	14.840	100,000	96,698	19,605,519,500	хямдруулсан	2015.04.21
13	1109	ЗГЭБ-Б-52-287	52	16.125	100,000	-	165,200,000	Сар бүр	2016.02.02
14	1110	ЗГЭБ-Б-12-288	12	14.896	100,000	96,686	2,114,909,564	хямдруулсан	2015.05.05
15	1111	ЗГХБ-Б-28-289	28	15.745	100,000	92,204	828,637,348	хямдруулсан	2015.09.01
16	1112	ЗГХБ-Б-12-290	12	15.019	100,000	96,659	22,607,186,874	хямдруулсан	2015.05.19
17	1113	ЗГЭБ-Б-52-291	52	16.625	100,000	-	1,521,500,000	Сар бүр	2016.03.01
18	1114	ЗГХБ-Б-12-292	12	15.54	100,000	96,547	649,471,669	хямдруулсан	2015.06.02
19	1115	ЗГХБ-Б-12-293	12	15.54	100,000	96,547	16,085,212,935	хямдруулсан	2015.06.02
20	1116	ЗГХБ-Б-28-294	28	16.00	100,000	92,088	490,184,424	хямдруулсан	2015.09.29
21	1117	ЗГХБ-Б-12-295	12	15.435	100,000	96,570	30,535,820,280	хямдруулсан	2015.06.16
22	1118	ЗГЭБ-Б-52-296	52	16.375	100,000	-	587,000,000	Сар бүр	2016.03.30
23	1119	ЗГХБ-Б-12-297	12	15.185	100,000	96,623	32,611,325,353	хямдруулсан	2015.06.30
24	1120	ЗГХБ-Б-28-298	28	15.80	100,000	92,179	244,458,708	хямдруулсан	2015.10.27
25	1121	ЗГЭБ-У-156-299	156	16.875	100,000	-	2,900,000	2015.08.15, 2016.02.15, 2016.08.15, 2017.02.15, 2017.08.15, 2018.04.14	2018.04.14
26	1122	ЗГХБ-Б-12-300	12	14.988	100,000	96,666	6,364,006,110	хямдруулсан	2015.07.14
27	1123	ЗГХБ-Б-12-301	12	14.988	100,000	96,666	13,843,924,524	хямдруулсан	2015.07.14
28	1124	ЗГЭБ-Б-52-302	52	16.00	100,000	-	2,089,100,000.00	Сар бүр	2016.04.28
29	1125	ЗГЭБ-У-260-303	260	16.75	100,000	-	2,000,000.00	2015.08.15, 2016.02.15, 2016.08.15, 2017.02.15, 2017.08.15, 2018.02.15, 2018.08.15, 2019.02.15, 2019.08.15, 2020.02.15, 2020.04.28	2020.04.28


ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИДЭВХ НЭМЭГДЭЖ БАЙНА

Дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвхийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 дахин нэмэгдэж, 111.7 тэрбум төгрөгт хүрч эрс нэмэгдсэн байна.

Үүний гол шалтгаан нь Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дахин арилжсан явдал бөгөөд тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг өнгөрсөн 1 дүгээр сард эхлүүлж, итгэмжлэгдсэн дилерийн тогтолцоог нэвтрүүлснээр үнэт цаасны хөрвөх чадвар нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна.



Гадаадын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн



Дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны дүн


ЗГҮЦ-НЫ НИЙТ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ 7.5 ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙНА

2014 оны 11 дүгээр сараас Засгийн газрын үнэт цаас Монголын хөрөнгийн биржээр арилжигдаж эхэлснээс хойш тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нийт 25 удаа явагдаж, 2.04 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Өнгөрсөн хугацаанд АНУ, Их Британи, БНСУ, Япон, Малайз зэрэг улсын болон дотоодын аж ахуйн нэгж, иргэд нийлсэн 221 хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаасанд 197.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 7.5 тэрбум төгрөгийн өгөөжийг хүртэхээр байна.

Монголын хөрөнгийн биржээр арилжигдаж буй ЗГҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкинд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү байдаг билээ. Өнгөрсөн хугацаанд Монгол улсын засгийн газар 197.3 тэрбум төгрөгийн үнэт цаасыг жигнэсэн дундаж хүүгээр арилжсанаар хүүгийн зардлаас оролцоогоор 107.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Өгөөжийн хэмжээ (Хувиар)



(Хугацаа: Долоо хоногоор)

МХБ-ИЙН 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Монголын хөрөнгийн бирж 2015 оны 1 дүгээр улиралд нийт 61 удаагийн арилжааг зохион байгуулж, 14 сая ширхэг үнэт цаасыг 111.7 тэрбум төгрөгөөр арилжлаа. Арилжааны үнийн дүнг 2014 оны мөн үетэй харьцуулахад 20.97 дахин өссөн бөгөөд өдөрт дунджаар 1.8 тэрбум төгрөгийн гүйлгээг хийлээ.

Мөн үнэт цаасны арилжаанд оролцсон гадаадын иргэд, аж ахуйн нэгжийн арилжааны нийт үнийн дүн нь 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 57 хувиар нэмэгдсэн байна.

Ингэснээр МХБ энэ оны 1 дүгээр улиралд нийт 361,615,230.12 төгрөгийн орлого олж 261,200,062.89 төгрөгийн зардал гаргасан байна. Үүнээс цалин, түүнтэй холбогдох зардалд нийт 171,913,344.11 төгрөг, ашиглалтын болон бусад зардалд 89,286,718.78 төгрөг зарцуулж, нийт 100,415,167.23 төгрөгийн ашигтай ажиллаа.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ БУУРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит 9 дүгээр хурлаар зарим Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулж шинэчлэн тогтоосон байна.

Үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдлыг сайжруулах, идэвхжүүлэх зорилгоор тус зах зээлийн зарим үйлчилгээний хөлсийг түр хугацаагаар чөлөөлжээ. Үүнд:

- Үнэт цаасны арилжаанаас Хөрөнгийн биржийн авч байсан шимтгэлийн орлогоос Хороо 10%-ийг төвлөрүүлдэг төлбөрийг;
- “ҮЦТТТХТ” ТӨХХК-ийн төлбөр тооцооны орлогоос 10%-ийг Хороонд төвлөрүүлдэг төлбөрийг;
- Андеррайтерийн үйлчилгээний жил бүр тогтмол төлж байсан 2 сая төгрөгийн хураамжийг тус тус 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр хугацаагаар чөлөөлжээ.

“ЖАВЛАНТ ХАРАА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ СЭРГЭЭН БҮРТГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06-р сарын 25-ны өдрийн 246 тоот тогтоол, “Жавхлант Хараа” хувьцаат компанийн 2015 оны 01-р сарын 12-ны өдрийн 01/121 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, дүгнэлтийн тус тус үндэслэж “Жавхлант Хараа” ХК-ийн гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 58,543 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэв.

“АРГАЙ БЭСТ ҮЦК” ХХК-ИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн №30 тоот албан шаардлагыг үндэслэн “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 4 сарын 6-ны өдрөөс эхлэн зогсоолоо.

“ГОЛОМТ СЕКЮРИТИЗ ҮЦК” ХХК-Д АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЭМЖ ОЛГОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 156 тоот тушаалаар “Голомт секюритиз ҮЦК” ХХК-д андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олголоо.

Ингэснээр “Голомт секюритиз ҮЦК” ХХК нь “Брокер”, “Хөрөнгө оруулалтын зөвлөх” болон “Андеррайтер”-ийн гэсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй боллоо.

ҮҮРГЭЭ ХУГАЦААНДАА БҮРЭН БИЕЛҮҮЛЭЭГҮЙ НЭР БҮХИЙ 27 ҮЦК БАЙНА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.4 дэх заалтуудын дагуу Гишүүн үнэт цаасны компани нь гишүүнчлэлийн жилийн хөлс болон арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлсийг улирал бүрийн эхний 10 хоногт багтаан төлөх үүрэг хүлээсэн байдаг. Энэхүү үүргээ хугацаандаа биелүүлээгүй дараах нэр бүхий 27 үнэт цаасны компани байна.

Энэхүү ҮЦК-иудад “Хамтран ажиллах гэрээ”-ний 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтын дагуу төлбөрийн үүрэг /хөлс, төлбөр/-ээ бүрэн биелүүлээгүй нөхцөлд Иргэний хуулийн 232.6-д заасныг үндэслэн хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцох ба 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хязгаарлахыг анхааруулж байна.


Үүргээ хугацаандаа бүрэн биелүүлээгүй нэр бүхий 27 ҮЦК-ийн нэрс:

- | | |
|-------------------------------|----------------------------|
| 1 АБЖЯ ХХК | 15 Зюс Капитал ХХК |
| 2 Ай трейд ХХК | 16 Лайфтайм Инвестмент ХХК |
| 3 Аргай Бэст ХХК | 17 Монгол секюритиес ХК |
| 4 Бага хээр ХХК | 18 Монет капитал ХХК |
| 5 Батс ХХК | 19 Новел инвестмент ХХК |
| 6 БиБиЭсЭс ХХК | 20 Нэйшнл Секюритис ХХК |
| 7 Блэкстоун интернэйшнл ХХК | 21 Превалент ХХК |
| 8 Булган Брокер ХХК | 22 Санар ХХК |
| 9 Глобал Ассет ХХК | 23 Таван толгой хишиг ХХК |
| 10 Говийн ноён нуруу ХХК | 24 Финанс Линк Групп ХХК |
| 11 ДиСиЭф ХХК | 25 Фронттиер ХХК |
| 12 Догсон ХХК | 26 Хүннү Эмпайр ХХК |
| 13 Дэлгэрхангай Секюритиз ХХК | 27 ЭфСиИкс ХХК |
| 14 ЗэтЖиБи ХХК | |

2015 ОНЫ I УЛИРЛЫН АРИЛЖААНЫ ТОЙМ МЭДЭЭ

2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 61 удаагийн арилжаагаар 87 компанийн 12.9 сая ширхэг хувьцааг 3.4 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны 12 удаагийн арилжаагаар 1.1 сая ширхэг үнэт цаасыг 108.3 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 111.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Өдөрт дунджаар 1.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 211.9 мянган ширхэг үнэт цаас арилжсан байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 3.04% буюу 3.4 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 96.96% буюу 108.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Компани нь олсон ашгаасаа хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчиддаа бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн үнэт цаас хэлбэрээр ногдол ашиг болгон хуваарилж болохоор өнөөгийн мөрдөгдөж буй Монголын Улсын хууль эрх зүйн хүрээнд заасан байдаг. Тухайн компанийн удирдлага буюу Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ нь жил бүрийн эхний 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй байдаг.

2015 оны 4 дүгээр сарын 14 –ны өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 237 хувьцаат компаниас 13 хувьцаат компани 140,447,981 ширхэг хувьцаанд 3.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн тогтоолоо Монголын хөрөнгийн биржид ирүүлсэн байна.

"УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2015" ЧУУЛГАНД Д.АНГАР ОРОЛЦОВ

2015 оны 4-р сарын 15-ны өдөр “Улаанбаатар Хөрөнгө оруулалт 2015” чуулга уулзалт “Блю Скай” төвд болж өнгөрлөө. Тус чуулганы “Олон улсын санхүүгийн төв, арбитр” сэдэвт салбар хуралдаанд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар оролцож Улаанбаатар хотын хөгжилд хөрөнгийн зах зээлийн оролцоо чухал болохыг онцолж, Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, МХБ-ийн бодлого үйл ажиллагааг танилцуулж, нийслэл орон нутгийн бондыг МХБ-ээр арилжиж, хөрөнгө босгох боломжуудын талаар танилцуулга хийлээ.



НЭГ ӨДРИЙН ЦАЛИНГАА ХАНДИВЛАЛАА




“Eagle” телевизийн сэтгүүлч Бадарчийн Жаргалмаа тархины хавдар гэх өвчний улмаас Тайланд улсад мэс засалд орсон бөгөөд хагалгаа амжилттай болж, одоогоор эрчимт эмчилгээ хийлгэж байгаа билээ. Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал болон Маркетинг,

олон нийттэй харилцах албаны хамт олон нэг өдрийн цалингаа Б.Жаргалмаагийн эмчилгээнд зориулан хандив өргөж, хурдан эдгэрэхийг хүсэн ерөөлөө.Сайн үйлс дэлгэрэх болтугай!

3, 6, 12 САРЫН ХУГАЦААТАЙ ЗГҮЦ-НЫ БОДИТ ӨГӨӨЖ


Богино хугацаат ЗГҮЦ /3, 6, 12 сар/ болон арилжааны банкуудын ижил хугацаат хадгаламжийн бодит өгөөжийн мэдээллийг хүргэж байна. ЗГҮЦ болон банкуудын хадгаламжийн хүү, өгөөжид нөлөөлөх хүчин зүйл нь татвар шимтгэл байх бөгөөд үүнээс гадна улсын жилийн инфляцийн төвшин юм. Энэ нь арилжааны банкуудын хадгаламж болон ЗГҮЦ-ны бодит өгөөжийг багасгах нь тодорхой юм. Иймд, хөрөнгө оруулагчийн бодит өгөөжийг дараах хүснэгтээс харна уу.

3 сарын хугацаатай хадгаламж, ЗГҮЦ-ны хүү



	Зарласан хүү /жил/	10%-ийн албан татвар ногдсоны дараах өгөөж / $(1) \times (1-10\%)$ /	МХБ, ҮЦТТТХТ, БДК-иудын шимтгэл / $(1)-0.0625\%$ /	Инфляцийн 9.3% хасагдсан өгөөж, / $(2)-9.3\%$ /
	(1)	(2)	(3)	(4)
ХХБанк	10.20	9.18	Дээрх байгууллагуудын арилжааны шимтгэл нь нийтдээ 0.0625% орчим бөгөөд зөвхөн ЗГҮЦ худалдан авах талд хамаарна.	-0.12
Хас банк	10.20	9.18		-0.12
Капитал банк	11.00	9.90		0.60
Голомт банк	11.40	10.26		0,96
Хаан банк	12.10	10.89		1,59
Төрийн банк	12.20	10.98		1,68
ЗГҮЦ	14.90	<i>ЗГҮЦ-ны хүүнд татвар тооцогдохгүй</i>	14,84	5,54

6 сарын хугацаатай хадгаламж, ЗГҮЦ-ны хүү



	Зарласан хүү /жил/	10%-ийн албан татвар ногдсоны дараах өгөөж / $(1) \times (1-10\%)$ /	МХБ, ҮЦТТТХТ, БДК-иудын шимтгэл / $(1) \times 0.0625\%$ /	Инфляцийн 9.3% хасагдсан өгөөж, / $(2) - 9.3\%$ /
	(1)	(2)	(3)	(4)
ХХБанк	13.20	11.88	Дээрх байгууллагуудын арилжааны шимтгэл нь нийтдээ 0.0625% орчим бөгөөд зөвхөн ЗГҮЦ худалдан авах талд хамаарна.	2.58
Хас банк	13.00	11.70		2.40
Капитал банк	13.00	11.70		2.40
Голомт банк	14.40	12.96		3.66
Хаан банк	14.10	12.69		3.39
Төрийн банк	14.20	12.78		3.48
ЗГҮЦ	15.80	<i>ЗГҮЦ-ны хүүнд татвар тооцогдохгүй</i>	15.74	6.44

12 сарын хугацаатай хадгаламж, ЗГҮЦ-ны хүү



	Зарласан хүү /жил/	10%-ийн албан татвар ногдсоны дараах өгөөж / $(1) \times (1-10\%)$ /	МХБ, ҮЦТТТХТ, БДК-иудын шимтгэл / $(1) \times 0.0625\%$ /	Инфляцийн 9.3% хасагдсан өгөөж, / $(2) - 9.3\%$ /
	(1)	(2)	(3)	(4)
ХХБанк	15.00	13.50	Дээрх байгууллагуудын арилжааны шимтгэл нь нийтдээ 0.0625% орчим бөгөөд зөвхөн ЗГҮЦ худалдан авах талд хамаарна.	4.20
Хас банк	14.50	13.05		3.75
Капитал банк	15.20	13.68		4.38
Голомт банк	15.60	14.04		4.74
Хаан банк	16.10	14.49		5.19
Төрийн банк	16.20	14.58		5.28
ЗГҮЦ	16.38	<i>ЗГҮЦ-ны хүүнд татвар тооцогдохгүй</i>	16.31	7.01

Т.ЖАМБААЖАМЦ: ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХ ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ БАЙСАН

Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх тухай журам”-ыг хэдхэн хоногийн өмнө баталсан. Уг журам батлагдсанаар хөрөнгийн зах зээлд хувьцаа болон бусад үнэт цаасны ханш чөлөөтэй, шударга, эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр тогтох боломжтой болох гэнэ. Өмнө нь хөрөнгийн зах зээлд давуу эрхтэй оролцох, үгсэн хуйвалдах явдал түгээмэл байжээ. Энэ талаар тус хорооны Хяналт шалгалтын газрын орлогч дарга Т.Жамбаажамцаас тодрууллаа.

-Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглана гэдэг нь ямар зөрчил вэ?

-Хөрөнгийн зах зээл дээр хориглосон хоёр төрлийн үйл ажиллагаа байдаг. Нэгдүгээрт, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, хоёрт зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл юм. Энэ хоёр үйлдлийг дэлхийн жишгээр хөрөнгийн зах зээлд байж болохгүй гэж үздэг. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиараа ч хориотой. Зах зээлийг урвуулан ашиглах зөрчил бол үнэт цаасны ханшийг зохиомлоор тогтоохыг хэлж байгаа юм. Үнэт цаасны үнэ ханш бол эрэлт нийлүүлт дээр үндэслэн хөдөлж байх ёстой. Гэтэл хоёр этгээд үгсэн хуйвалдсан эсвэл нэг ашиг сонирхолтой хэсэг хүмүүс хоорондоо хуйвалдаад хувьцааны үнийг өсгөх, буруулах зэрэг үйлдлийг хийдэг. Эдгээрийг тус журмаар нарийвчлан зохицуулсан юм. Мөн зах зээлийг урвуулан ашиглах үйлдлийг өнгөрсөн онд өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцдог болсон. Энэ бол томоохон зөрчил бөгөөд зах зээлд итгэх итгэлийг буруулдаг, хөрөнгийн зах зээлд



асар их сөрөг нөлөө үзүүлдэг үйлдэл юм.

-Дотоод мэдээлэл ашиглах зөрчлийн талаар арай дэлгэрүүлнэ үү?

-Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой. Эсвэл томоохон гэрээ хэлцлийн мэдээлэл хөрөнгийн зах зээлд ил тод байх ёстой. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдыг тэгш мэдээллээр хангах үүрэгтэй гэсэн үг. Гэтэл тодорхой шийдвэр гаргах төвшний нөхөд энэ мэдээллийг ашиглаж, давуу эрх эдлэх боломжтой. Тэр мэдээлэл зах зээл дээр ханшийг өсгөдөг ч байж болно. Үүнийг ашиглаж компанийн эрх бүхий захирлууд хувьдаа ашиглан бусдыг хохироодог. Энэ нь дотоод

мэдээлэл ашиглах зөрчил юм. Өмнө нь зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглах зөрчил нийтлэг байсан. Тухайлбал, хоёрхон хүн тодорхой хувьцааны үнийг өсгөдөг, унагадаг асуудал байх жишээтэй. Ер нь үүнээс өмнө хөрөнгийн зах зээлийг нарийн зохицуулсан журам байгаагүй юм.

-Ийм төрлийн хэчнээн зөрчил илэрсэн бэ?

-Бид өнгөрсөн жилийн гуравдугаар сараас эхлэн хяналт шалгалт хийсэн. Энэ хугацаанд үнэт цаасны зах зээлийн эрхтэй дөрвөн мэргэжилтний эрхийг түр хугацаанд хассан. Мөн нэг мэргэжилтний эрхийг бүр мөсөн цуцласан байгаа. Илэрсэн зөрчил нь үнэ ханшийг зохиомлоор өсгөсөн байсан.

-Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөгжил сайн байсангүй. Иймэрхүү нарийн зохицуулалт байгаагүй нь нөлөөлж байсан уу?

-Үүнд нөлөөлсөн их олон шалтгаан байгаа л даа. Үнэ ханшийг зохиомлоор өсгөдөг, буулгадаг явдал тодорхой хэмжээнд нөлөөлж байсан гэж үзэж болно. Гэхдээ гол шалтгаан бол зах зээлд бүтээгдэхүүн алга, томоохон худалдан авагчгүй байгаа явдал юм.

-Ер нь давуу эрх эдэлсэн, зах зээлийг урвуулан ашиглах зөрчил гаргасан аж ахуйн нэгжид ямар арга хэмжээ авдаг вэ?

-Ийм зөрчил гаргасан таван брокерт арга хэмжээ авахад маш их эсэргүүцэлтэй тулгарсан. Өмнө нь хийдэг л байсан. Ингээд л үнэ тогтоодог гэх мэтээр хүлээж авсан. Энэ бол олон улсын стандарт, хуулиараа зөрчил мөн. Хамгийн гол нь үнийг зохиомлоор өсгөхөд хэн хохирсон юм бэ гэдэг. Мөн хохирсон хүн байхгүй байхад яагаад зөрчил гэж үздэг юм бэ гэдэг асуудал ярьдаг. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч байхгүй гэж үзээд байгаа. Хохирогч байна, байхгүй нь огт хамаагүй. Дээрх хоёр үйлдлийг хийсэн байхад л зөрчил гэж үздэг. Учир нь үнэт цаасны зах зээл бол цэвэр итгэлцэл дээр тогтдог. Эрх бүхий хоёр хүн дураараа удирддаг зах зээлд хэн орж ирэх юм бэ. Хэн ч орж ирэхгүй. Мэдээлэл нь ил тод шударга өрсөлдөөн дээр тогтсон зах зээл рүү хүн мөнгөө оруулна. Хариуцлагын хувьд өндөр торгуультай. Эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүн байвал тохирсон арга хэмжээ авна. Мөн 19 сая төгрөгөөр торгох заалттай. Бид өнөөдөр бизнес нь тогтоогүй, чадавхгүй байгаа брокерүүдэд өндөр торгууль тавихаас илүү эрхийг нь түр хасах арга хэмжээ авч байгаа. Харин дээрх үйлдлээ дахин давтсан тохиолдолд торгуулийн арга хэмжээ авах зэргээр хариуцлагыг өндөрсгөнө.

Эх сурвалж:

“Үндэсний Шуудан” 2015.3.30
Д.МЯГМАРДОРЖ



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ
ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2015 оны 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 1-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	1,124,007
Нийт үнийн дүн /төг/	55,462,024,680.80
Хэлцлийн тоо	1005
Арилжигдсан үнэт цаасны тоо	73
Зах зээлийн үнэлгээ /төг/	1,281,492,495,061


ТОП-20 индекс

Хаалт	13,082.01
Өөрчлөлт /%/	-0.11

MSE ALL индекс

Хаалт	951.97
Өөрчлөлт /%/	-0.66

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	GNR	ГОНИР	160,332	1	APU	АПУ	88,539,888
2	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	102,736	2	GNR	ГОНИР	25,653,120
3	ETR	Э-ТРАНС ЛОЖ ИСТИКС	80,146	3	TCK	ТАЛХ ЧИХЭР	15,633,320
4	MRX	МЕРЕКС	57,447	4	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	13,356,606
5	RMC	РЕМИКОН	53,947	5	GOV	ГОВЬ	13,264,840

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BVK	УБ-БУК	40,200		30.94
2	AOI	АВТО ИМПЕКС	3,300		10.00
3	BDS	БИ ДИ СЕК	1,750		9.03
4	GOV	ГОВЬ	7,790		5.91
5	TCK	ТАЛХ ЧИХЭР	18,980		5.80

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	ADL	АДУУН ЧУЛУУН	1,350		-28.95
2	BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	571		-27.21
3	IBA	ИХ БАРИЛГА	6,500		-18.75
4	SHG	ШАРЫН ГОЛ	4,202		-15.96
5	CHR	УВС ЧАЦАРГАНА	2,125		-15.00

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Нэгж үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-12-297	337,511	32,611,325,353	96,623	12	15.185
2	ЗГХБ-Б-28-298	2,652	244,458,708	92,179	28	15.80
3	ЗГЭБ-У-156-299	29	2,900,000	100,000	156	16.875
4	ЗГХБ-Б-12-300	65,835	6,364,006,110	96,666	12	14.988
5	ЗГХБ-Б-12-301	143,214	13,843,924,524	96,666	12	14.988
6	ЗГЭБ-Б-52-302	20,891	2,089,100,000	100,000	52	16.00
7	ЗГЭБ-У-260-303	20	2,000,000	100,000	260	16.75

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Нэгж үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ZGEB-BL-02/06/15-A0019-0	10	960,000	96,000	12	15.54
2	ZGEB-BL-02/06/15-A0019-0	10	981,000	98,100	12	15.54
3	ZGEB-BL-30/06/15-A0023-0	1	97,300	97,300	12	15.185
4	ZGEB-BD-30/03/16-A0024-16.375	34	3,401,360	100,040	52	16.375